

АРЛИНГТОНЫ УЛСЫН СУРГУУЛЬ
2110 WASHINGTON BLVD
ARLINGTON, VA 22204
TEL. (703-228-8000

“SECTION 504” ПРОЦЕДУРЫН ХАМГААЛАЛТ

1973 оны Нөхөн Сэргээлтийн Тухай Хуулийн¹ 504-р Хэсгийн (Section 504²) дагуу Арлингтоны Улсын Сургууль таны хүүхдэд хамаарах дараах эрх зүйн хамгаалалтуудыг танд олгож байна.

1. Та хүүхдийнхээ таньж илрүүлэлт, үнэлгээ болон хөтөлбөрт хуваарилахтай холбоотой санал болгож буй аливаа арга хэмжээний талаар мэдэгдэл хүлээн авах эрхтэй.
2. Та хүүхдийнхээ холбогдох бүх бүртгэлийг шалгах эрхтэй.
3. Та Америкийн Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Тухай Хуулийн³ (ADA) 504-р хэсэг эсвэл II Зүйл (Title II)-г зөрчсөн гэх үндэслэлээр сургуулийн дүүрэгт гомдол гаргах эрхтэй.
4. Та хүүхдийг таньж илрүүлэх, үнэлэх болон хөтөлбөрт хуваарилахтай холбоотой маргаанаар өөрийн болон өмгөөлөгчийн оролцоотойгоор хараат бус сонсгол явуулах эрхтэй.
5. Хэрэв та шийдвэртэй санал эс нийлэх аваас хараат бус сонсголын ажилтны эцсийн шийдвэрт хяналт хийлгэх эрхтэй.

Арлингтоны Улсын Сургуулийн “Section 504” Хөтөлбөрийн Зохицуулагч нь Женнифер Ламбдин (Jennifer Lambdin) юм. Тус албатай дараах утсаар холбогдож болно. (703) 228-8838. ADA-ийн 504-р Хэсэг эсвэл II Зүйлтэй холбоотой аливаа асуултыг “Section 504” Хөтөлбөрийн Зохицуулагчтай холбогдож тодруулна уу. Та Арлингтоны Улсын Сургуулийн “Section 504” Хөтөлбөрийн Журмын Гарын Авлагыг “Section 504” Хөтөлбөрийн Зохицуулагчтай дээрх утсаар холбогдож авах эсвэл Арлингтоны Улсын Сургуулийн <https://www.apsva.us/> вэбсайтаас авна уу. Бүх гомдол болон хараат бус сонсгол, хяналт шалгалтын хүсэлтүүдийг бичгээр гаргаж, доорх хаягуудаар Арлингтоны Улсын Сургууль (АУС)-н “Section 504” Журмын гарын авлагад заасны дагуу “Section 504” Хөтөлбөрийн Зохицуулагч эсвэл “Section 504” Хөтөлбөрийн Хэрэгжилт Хянах Ажилтанд илгээх шаардлагатайг анхаарна уу:

Jennifer Lambdin
“Section 504” Зохицуулагч
Arlington Public Schools
2110 Washington Blvd
Arlington, VA 22204
Tel. (703) 228-8838
Email: jennifer.lambdin@apsva.us

Dr. Darrell Sampson
“Section 504” Хэрэгжилт Хянах Ажилтан
Сурагчийн Үйлчилгээний Алба, Гүйцэтгэх Захирал
Arlington Public Schools
2110 Washington Blvd
Arlington, Va 22204
Tel. (703) 228-6061
Email: darrell.sampson@apsva.us

“Section 504” Хөтөлбөрийн сонсголын журам, гомдол гаргах журам, хяналтын журмын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг сургуулийн дүүргийн “Section 504” Хөтөлбөрийн журмын гарын авлагад багтаасан болно.

¹ Rehabilitation Act of 1973- 1973 оны Нөхөн Сэргээлтийн Тухай Хууль.

² 1973 оны Нөхөн Сэргээлтийн Тухай Хуулийн 504-р заалт нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн боловсролын эрхийг хамгаалах заалт юм. Тус заалтын дагуу хэрэгждэг үйлчилгээг цаашид “Section 504” гэж товчилно.

³ Americans with Disabilities Act- Америкийн Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн хууль. Цаашид ADA гэх.